БИЕ ДААН ХҮҮХЭД ҮРЧЛҮҮЛЭХ

ХӨТӨЛБӨРИЙН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

Хүүхэд үрчлүүлэн өгөх зөвшөөрөлд гарын үсэг зурснаар та өөрийнхөө үр хүүхдийг бусдад үрчлүүлэн өгөхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж байгаа болно. Зөвшөөрөх гэдэг нь тухайн хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргасан хүмүүст бүр мөсөн үрчлүүлэн өгч, түүний/тэдний хүүхэд болгон өсгөн хүмүүжүүлэх зорилготой байх гэсэн үг юм. Хүүхэд үрчлэх хүсэлтийг шүүхээс баталсан тохиолдолд уг хүүхдийн эцэг, эх байх бүхий л эрх тань хүчингүй болно.

Уг санамж бичиг болон Хүүхэд үрчлүүлэн өгөх зөвшөөрлийн хуудсыг бөглөж гарын үсгээ зурахаас өмнө дор хавсаргасан мэдэгдлийг уншаад, бүрэн танилцсаны дараа асуух зүйл гарвал Үрчлэлтийн агентлаг эсвэл Калифорнийн нийгмийн халамж үйлчилгээний төвийн төлөөлөгчөөс лавлаж асууна уу.

Эдгээр мэдэгдлийн аль нэгийг бүрэн гүйцэт ойлгоогүй тохиолдолд сайтар лавлаж асуух нь чухал юм. Үр хүүхдээ бусдад үрчлүүлэн өгөхийг зөвшөөрөх асуудал нь нэн чухал шийдвэр тул уг шийдвэрийг гаргахаас өмнө бүх баримт, мэдээлэлтэй сайтар танилцсан байх ёстой.

Харилцан ойлголцлын санамж бичгийг бөглөх заавар

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ БА ХҮҮХЭД ҮРЧЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛД ГАРЫН ҮСГЭЭ ЗУРАХЫН ӨМНӨ ДООРХИ ЗҮЙЛИЙГ АГЕНТЛАГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХАМТ МАШ АНХААРАЛТАЙ УНШИНА УУ. БҮРЭН ГҮЙЦЭТ ОЙЛГООГҮЙ ТОХИОЛДОЛД САЙТАР ЛАВЛАЖ АСУУХ НЬ ЧУХАЛ ЮМ.

1. *Та үр хүүхдээ бусдад үрчлүүлэн өгөх талаар, тэрчлэн таны хүүхдийг үрчлэн авах хүсэлт гаргасан хүмүүст хүүхдээ үрчлүүлж өгөхдөө бүрэн итгэлтэй байгаа эсэх талаар сайтар эргэцүүлэн бодсоны дараа л уг Харилцан ойлголцлын санамж бичгийг бөглөнө үү.*
2. *Энд хавсаргасан мэдэгдэл тус бүрийг маш анхааралтай уншина уу. Хэрэв аливаа нэг зүйлийг бүрэн гүйцэт ойлгохгүй байгаа бол зуучлах агентлагийн төлөөлөгчөөс сайтар лавлаж асууна уу.*
3. *Санамж бичгийг уншиж танилцаад, бүрэн гүйцэт ойлгоод хүлээн зөвшөөрч буй тохиолдолд мэдэгдэл тус бүрийн хажуу талд байрлах нүхэнд овог, нэрийнхээ эхний үсгийг бичнэ үү.*
4. *Хэрэв тухайн мэдэгдэлтэй санал нийлэхгүй байгаа бол эсвэл агентлагийн төлөөлөгчийн тайлбарлаж өгсний дараа ойлгохгүй хэвээр байгаа тохиолдолд овог нэрийнхээ эхний үсгийг бичилгүй хоосон үлдээнэ үү.*
5. *Хэрэв та бүх нүхэнд овог нэрийнхээ эхний үсгийг бичиж бөглөсөн бол хамгийн сүүлийн хуудсан дээр гарынхаа үсгийг зурна уу.*
6. *Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичиг болон Хүүхэд үрчлүүлэн өгөх зөвшөөрлийн хуудсыг бүрэн бөглөж, бүрдүүлсний дараа тэдгээрийн нэг хуулбарыг танд өгөх болно.*

ЭНЭ ХУУДСЫГ ДАРААХЬ АНКЕТЫН АЛЬ НЭГИЙН ХАМТ АШИГЛАХ ЁСТОЙ.

AD 1A, AC 1C, AD 1F, AD 165, AD 166 ЭСВЭЛ AD 4336

ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

Хүүхдийн эцэг эх байх эрхээ хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан хүн/хүмүүст өгсөн эцэг эсвэл эх

☐ 1. Би өөрийн төрсөн үр хүүхэд болох _____-ийг
ХҮҮХДИЙН ОВОГ НЭР
_____ (хүсэлт гаргагч(ид)) нарт үрчлүүлэн өгөх
ХҮСЭЛТ ГАРГАГЧ(ИД)-ЫН ОВОГ, НЭР
хүсэлтэй байна.

☐ 2. Хүсэлт гаргагчдын талаарх дараахь мэдээлэлд үндэслэн тэдгээр нэр заасан хүмүүст өөрийн хүүхдийг үрчлүүлэн өгөхөөр шийдсэн болно.

Нэгдүгээр хүсэлт гаргагч хүн:

Хууль ёсны овог, нэр _____

Нас _____ Шашин шүтлэг _____ Яс үндэс, угсаа гарал _____

Урьд өмнөх гэрлэлтийн тоо _____ Хийдэг ажил _____

Өдөр тутмын хэвийн ажиллагааг алдагдуулах эсвэл амьдралын хугацааг богиносгох өвчлөлтэй эсэх

_____

_____

Тэдэнтэй хамт амьдардаггүй үр хүүхдүүд бий эсэх, хүүхдийн тэтгэвэр төлдөг эсэх, тэтгэвэр төлөлгүй орхигдуулсан эсэх

_____

_____

Замын хөдөлгөөний зөрчлөөс өөр хүнд ноцтой гэмт хэрэг оролцон, баривчлагдаж байсан эсэх

_____

_____

Хүүхэд зодож хүчирхийлсэн, хайхрамжгүй хандсан шалтгаанаар хүүхэд өсгөх эрхийг нь хасч байсан эсэх

_____

Хоёрдугаар хүсэлт гаргагч хүн:

Хууль ёсны овог, нэр _____

Нас _____ Шашин шүтлэг _____ Яс үндэс, угсаа гарал _____

Урьд өмнөх гэрлэлтийн тоо _____ Хийдэг ажил _____

Өдөр тутмын хэвийн ажиллагааг алдагдуулах эсвэл амьдралын хугацааг богиносгох өвчлөлтэй эсэх

_____

_____

Тэдэнтэй хамт амьдардаггүй үр хүүхдүүд бий эсэх, хүүхдийн тэтгэвэр төлдөг эсэх, тэтгэвэр төлөлгүй орхигдуулсан эсэх

_____

_____

Замын хөдөлгөөний зөрчлөөс өөр хүнд ноцтой гэмт хэрэг оролцон, баривчлагдаж байсан эсэх

_____

_____

Хүүхэд зодож хүчирхийлсэн, хайхрамжгүй хандсан шалтгаанаар хүүхэд өсгөх эрхийг нь хасч байсан эсэх

_____

_____

Гэр бүл:

Одоогийн гэрлэлтийн үргэлжилж буй хугацаа: _____
Одоогийн оршин суугаа газрын хаяг:

_____

_____

Хүсэлт гаргагчийн гэрт амьдардаг бусад үр хүүхдүүд ба насанд хүрсэн хүмүүс:

_____

_____

☐ 3. Бие даан хүүхэд үрчлүүлэх процессын үеэр хуульч өмгөөлөгч хөлслөн хуулийн зөвлөгөө авах эрхтэй ба хүсэлт гаргагч(ид)-тай тохиролцохдоо үүнээс илүү их хэмжээний мөнгө төлөхөөр заагаагүй тохиолдолд хуулийн зөвлөгөө авахтай холбогдох 500 хүртэлх долларын зардлыг хүсэлт гаргагч(ид) хариуцах болно гэдгийг би бүрэн ойлгож байна.

☐ 4. Үр хүүхдээ бусдад үрчлүүлэн өгөх гэж буй төлөвлөгөөнийхөө тухай бусад мэргэжлийн хүмүүс, өөрийн гэр бүлийн гишүүд, найз нөхөдтэйгээ хуваалцах эрхтэй гэдгээ би ухамсарлан ойлгож байна.

☐ 5. Хэрэв би хүүхдээ бусдад үрчлүүлэн өгөх талаар бүрэн итгэлгүй байх тохиолдолд уг агентлагаас надад тус болох, тухайлбал гэр бүл, эрүүл мэнд, мөнгө санхүү, бусад асуудлаар туслах өөр байгууллагыг санал болгох болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 6. Хэрэв би хүүхдээ үрчлүүлэн өгөх зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурахгүй бол Үрчлүүлэх зөвшөөрлөөс татгалзах хуудсыг (AD 20) бөглөөд гарын үсэг зурах эсвэл үрчлэлтийн агентлаг руу өргөдөл бичих эрхтэй ба ингэсэн тохиолдолд хүсэлт гаргасан хүмүүст хүүхдээ үрчлүүлэх хүсэлгүй байгааг зуучлах агентлагаас шүүхэд мэдэгдэх болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 7. Үрчлүүлэх зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зураагүй тохиолдолд өөрийнхөө хүүхдийг буцааж авахыг хүсч болно. Хүсэлт гаргагчид хүүхдийг минь буцааж өгөхгүй байх тохиолдолд би хүүхдээ буцааж авах зорилгоор шүүхэд хандах эрхтэй болно. Ингэхийн тулд надад хуульч өмгөөлөгч шаардлагатай болж магадгүй гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 8. 30 хоногийн хугацаа дуусангуут эсвэл Үрчлүүлэх зөвшөөрлийг цуцлах эрхээсээ татгалзсан (AD 929) тохиолдолд миний зөвшөөрөл шууд эргэлт буцалтгүй хүчин төгөлдөр болно. 30 хоногийн эхний өдөр бол Үрчлүүлэх зөвшөөрөлд гарын үсэг зурсан өдөр гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 9. Үрчлүүлэх зөвшөөрөлд гарын үсэг зурсний дараа би бодлоо өөрчилвөл тухайн үрчлэлтийн асуудлыг хариуцаж буй Калифорнийн нийгмийн халамж үйлчилгээний төв эсвэл төлөөлөгдсөн тойргийн үрчлэлтийн агентлагт бичгэн хэлбэрээр өргөдөл гаргах замаар зөвшөөрлөө цуцалж, хүүхдээ буцааж авах хүсэлтийг гаргах ёстой болно. Зөвшөөрөлд гарын үсэг зурснаас 30 хоногийн дараа эсвэл Үрчлүүлэх зөвшөөрлийг цуцлах эрхээсээ татгалзах (AD 929) хуудсыг бөглөж гарын үсэг зурсан тохиолдолд зөвшөөрлөө цуцлах боломжгүй болно. 30 хоногийн эхний өдөр бол Үрчлүүлэх зөвшөөрөлд гарын үсэг зурсан өдөр гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 10. Үрчлүүлэх зөвшөөрөл нь нэгэнт эргэлт буцалтгүй хүчин төгөлдөр болсон бол гагцхүү хүсэлт гаргагчид өөрсдөө үрчилж авах хүсэлтээ татаж авах тохиолдолд, эсвэл шүүхээс уг үрчлэлтийг батлаагүй тохиолдолд л хүүхдээ эргүүлэн авах боломжтой болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 11. Уг үрчлэлтийг шүүхээс батлах хүртэл би тухайн хүүхдийн хууль ёсны асран хүмүүжүүлэгч хэвээр байх болно. Хэрэв тухайн хүүхдийг үрчлээгүй бол зуучлах агентлагаас энэ талаар надад мэдэгдэж, хүүхдийн ирээдүйн талаар өөр төлөвлөгөө гаргахыг хүсэх болно. Би оршин суугаа газрынхаа хаягийг тухайн агентлагт байнга мэдэгдэж байх ёстой гэдгийг ухамсарлан ойлгож байгаа болно.

☐ 12. Би хүсэлт гаргагчдын талаар болон миний хүүхэд тэдний гэрт хэрхэн яаж зохицон дасах талаар хангалттай мэдээлэл олж авсан бөгөөд хүүхдээ үрчлүүлэн өгөх зөвшөөрөлд гарын үсэг зурах хүсэлтэй байна.

☐ 13. Шүүхээс хүүхэд үрчлэх хүсэлтийг баталсан тохиолдолд би тухайн хүүхдийн эцэг, эх байх эрхээ бүр мөсөн алдана гэдгийг би ухамсарлан ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл,

А. Тухайн хүүхдийг асран хүмүүжүүлэх хариуцлагыг хүлээхгүй болно

Б. Тухайн хүүхдийг асран хүмүүжүүлэх хууль ёсны хариуцлагыг хүсэлт гаргагчид үүрэх болно.

В. Тухайн хүүхдийн асрамжлах эрх, түүнд хамаарах аливаа орлого ашгаас хуваалцах эрхгүй болно.

☐ 14. Тухайн үрчлэлтийн асуудалд зуучилж буй агентлагаас ирээдүйд ямарваа нэгэн мэдээлэл хүсэх тохиолдолд уг үрчлэлттэй холбогдох бүх мэдээллийг, тэр дундаа хүүхэд үрчлэх процесс хэзээ дуусгавар болох тухай, үрчлэлтийн процесс таслагдаж, хойшлогдсон бол миний хүүхдийг өөр айлд үрчлүүлэхээр төлөвлөж байгаа эсэх тухай мэдээлэл өгөх болно гэдгийг би ухамсарлан ойлгож байгаа.

☐ 15. Хүүхэд үрчлүүлэх хүсэлтийг шүүхээс баталсны дараа аливаа цусан төрлийн хамаатан саднаас хүүхдийг маань гэрээслэлдээ нэр цохон зааснаас бусад бүх тохиолдолд өв залгамжлах эрх хүчингүй болно. Миний хүүхэд өөрийг нь үрчлэн авсан эцэг, эхийнхээ өв залгамжлагч болно гэдгийг би ухамсарлан ойлгож байгаа.

☐ 16. Хүүхдээ хууль ёсоор үрчлүүлэн өгсний дараа буцааж авах эрхгүй болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 17. Зуучлах агентлаг нь дараахь тохиолдолд үрчлэлтийн хавтаст хэргээс мэдээлэл өгөх болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

А. Миний хүүхдэд тус болох үүднээс хуулинд заасан тодорхой байгууллагаас мэдээлэл хүсэх

Б. Хүүхэд насанд хүрч надтай холбоо барихыг хүсэх, ингэхдээ бид хоёр үүнийг харилцан зөвшөөрч гарын үсэг зурсан байх

В. Хүүхэд 21 нас хүрч миний тухай мэдээлэл олж авахыг хүсэх ба би ийнхүү мэдээлэл өгөхийг зөвшөөрсөн байх

Г. Хүүхэд 21 нас хүрч, надад өөрийнхөө үрчлэгдсэний дараахь овог нэр, оршин суугаа газрынхаа хаягийг өгөхийг зөвшөөрч гарын үсэг зурсан байх ба би тэрхүү мэдээллийг хүсэх

Д. Хүүхэд 21 нас хүрсэн тохиолдолд зуучлах агентлагаас хуулийн хүрээнд миний овог, нэр, оршин суугаа газрын хаягийг өгөх эрхтэй байна.

☐ 18. Бие даан хүүхэд үрчлэх процесст зуучилж өгсөн агентлагын архив дахь өөрийн хавтаст хэрэгт мэдээлэл нэмж оруулах эрхтэй гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 19. Шүүхэд гаргасан миний хүсэлтийг харгалзан үзсэний үндсэн дээр шүүхийн архиваас мэдээлэл гаргаж өгөх болно гэдгийг би ухамсарлан ойлгож байна.

☐ 20. Хүүхэд үрчлэн авах гэсэн жинхэнэ шалтгааныг надаас нуун дарагдуулсан байна гэж үзвэл би хүүхдээ үрчлүүлснээс хойш гурван жилийн дотор шүүхэд хандаж, миний хүүхдийн бусдад үрчлэгдсэнийг таслан зогсоохыг хүсэх эрхтэй гэдгээ би ухамсарлан ойлгож байгаа.

☐ 21. Хүүхдээ өөртөө үлдээх эсвэл бусдад үрчлүүлэн өгөх шалтгааны талаар би сайтар эргэцүүлэн бодсон. Хүсэлт гаргасан хүмүүст хүүхдээ үрчлүүлэн өгөх нь миний хүүхдийн эрх ашигт илүү нийцэх болно гэж шийдлээ. Уг харилцан ойлголцлын санамж бичиг ба Үрчлүүлэх зөвшөөрлийн хуудсыг уншиж, бүрэн гүйцэт ойлголоо. Шийдвэр гаргахад минь нэмэлт туслалцаа эсвэл хугацаа шаардлагагүй. Хүсэлт гаргасан хүмүүст хүүхдээ үрчлүүлэн өгөхөөр шийдсэн тул сайн дурын үндсэн дээр гарын үсгээ зурлаа.

Миний бие _____ _____
ЭЦЭГ/ЭХИЙН ОВОГ, НЭР ХҮҮХДИЙН ОВОГ, НЭР

-ийн эцэг/эх мөн бөгөөд дээрхи мэдэгдлийг бүрэн гүйцэт ойлгож, овог нэрийнхээ эхний үсгээр баталгаажуулж зөвшөөрлөө.

_____ _____
ОН, САР, ӨДӨР ЭЦЭГ/ЭХИЙН ГАРЫН ҮСЭГ

Калифорниа мужид гарын үсэг зурж буй тохиолдолд А ХЭСГИЙГ бөглөнө үү.

А ХЭСЭГ

Миний бие _____ нь _____
ОВОГ, НЭР БА АЛБАН ТУШААЛ АГЕНТЛАГИЙН НЭР

байгууллагын эрх бүхий төлөөлөгч бөгөөд _____
ЗӨВШӨӨРӨЛ ӨГЧ БУЙ ЭЦЭГ/ЭХИЙН ОВОГ, НЭР

_____-ний өдөр миний өмнө уг Харилцан ойлголцлын санамж бичигт
ОН, САР, ӨДӨР

гарын үсэг зурсан болохыг гэрчлэв.

_____
ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАРЫН ҮСЭГ

Калифорниа мужын гадна гарын үсэг зурж буй тохиолдолд Б ХЭСГИЙГ бөглөнө үү.

Б ХЭСЭГ

_____ МУЖ)
)
_____ ТОЙРОГ)

_____ өдөр миний бие, Нотариатч, _____-ийн өмнө

өөрсдийн биеэр хүрэлцэн ирсэн _____
ЭЦЭГ/ЭХИЙН ОВОГ НЭР

уг өргөдөл дээр нэр заасан хүн мөн болохоо (шаардлага хангахуйц нотолгоо, баримт бичиг бүрдүүлж өгсний үндсэн дээр), тэрчлэн өөрийн хууль ёсны эрхийн хүрээнд ийнхүү гарын үсэг зурсан болохоо баримтаар нотолсон тул түүний овог, нэр үнэн зөв болохыг ийнхүү нотариатаар батлав.

ГЭРЧИЙН гарын үсэг, тамга тэмдэг.

_____ (Тамга)
Гарын үсэг